

ГАРЧИГ

Өмнөх үг	2
Судалгааны зорилго	4
Судалгааны аргачлал	4
Судалгаанд оролцогсдын нийгэм хүн ам зүйн үзүүлэлт . .	5
Судалгааны дүнгээс	7
◆ Хот хөдөөд хэвлэл мэдээллийн хэрэгслийг хэрхэн ашиглаж байна вэ?	7
◆ Мэдээллийн хэрэгслийн иргэдийн амьдралд гүйцэтгэх үүрэг өөрчлөгдөж байна	10
◆ Хот хөдөөд сонин уншиж буй байдал	11
◆ Хэвлэл мэдээллийн итгэл үнэмшил	12
◆ Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай олон нийтийн ойлголт, үнэлэмж	14
◆ Өнөөдөр Монгол Улсад хэвлэлийн эрх чөлөө ямархуу түвшинд байна вэ?	15
◆ Хэвлэлийн эрх чөлөөнд юу сайнаар нөлөөлж байна вэ?	19
◆ Хэвлэлийн эрх чөлөөнд юу саад болж байна вэ?	20
◆ Сүүлийн жилүүдэд хэвлэл мэдээллийн эрх чөлөөт байдал хэрхэн өөрчлөгдсөн вэ?	20
◆ Survey on Public Assessment “Media Freedom in Mongolia Today”	22
◆ Summary of survey results	22

ӨМНӨХ ҮГ

Монгол оронд хөгжин төлөвшиж буй ардчилсан тогтолцооны нэгэн томоохон ололт бол үг хэлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөг бий болгосон явдал мөн. 1989 оны эцэст төрийн харъяалал бүхий, төр, засгаас нийтлэл нэвтрүүлгийн бодлогыг нь тодорхойлдог 70 гаруй сонин хэвлэл гарч байсныг өнөөдрийн нөхцөл байдалтай харьцуулвал, Монголын хэвлэл мэдээллийн салбарт хувьсгал гарч, үг хэлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөг эдлэх боломж нээлттэй болжээ хэмээн дүгнэж болох мэт. 2003 оны эцсийн байдлаар Монголд 170 гаруй сонин, 60-аад сэтгүүл гарч, 40 радио, 35 телевиз үйл ажиллагаа явуулж буйгийн зэрэгцээ хот хөдөөд нийт 16 кабелийн телевизээр гадаад, дотоодын 50 гаруй сувгийг хүлээн авах боломжтой байв. Сонин хэвлэлийн 63%, радио, телевизийн 37% нь хувийн хэвшилд үйл ажиллагаа явуулж байна.

Хэвлэл мэдээллийн хэрэгслийн тоо, эзэмшил харъяаллын олон хэлбэр нь хэвлэл мэдээллийн эрх чөлөө хэрэгжиж буйн нэгэн илрэл байж болох авч, хэвлэлийн эрх чөлөө хэрхэн хэрэгжиж буйг дүгнэхийг хүсвэл бусад шалгуурыг харгалзан үзэх шаардлагатай. Үүнд тухайлбал хэвлэлийн эрх чөлөөг хөгжүүлэх хууль эрх зүйн орчин хэрхэн хэрэгжиж байгаад дүгнэлт хийхийн зэрэгцээ ардчилсан сэтгүүл зүйн үндсэн зарчмууд практик сэтгүүл зүйд хэрэгжиж байгаа эсэхийг тунгааж үзэх нь зүйтэй болов уу. Нэн ялангуяа хараат бус, тэнцвэртэй мэдээлэл түгээх мэдлэг чадвар, нөхцөл байдал төлөвшсөн эсэх, сэтгүүлчид нийгмийн өмнө хүлээх үүрэг хариуцлагаа ухамсарлаж байгаа байдал, сэтгүүл зүйн ёс зүйн асуудал ямархуу түвшинд байгааг бодолцох нь чухал. Үүний зэрэгцээ, нийт олон түмэн хэвлэлийн эрх чөлөөг хэрхэн ойлгож, үнэлж байгаа байдал нь хэвлэлийн эрх чөлөөний талаар дүгнэлт хийх нэгэн чухал үзүүлэлт яах аргагүй мөн.

Чухам энэхүү үнэлэмж, хэвлэлийн эрх чөлөөний талаарх олон түмний үнэлэлт дүгнэлтийг тандан судлах

зорилгоор Хэвлэлийн Хүрээлэнгийн мэдээлэл судалгааны албанаас “Монголын хэвлэл мэдээллийн байдлын талаарх олон нийтийн үнэлэмж” судалгааг орон даяар явууллаа. Хэвлэлийн Хүрээлэнгээс 1998 онд Монголын хэвлэлийн эрх чөлөөний тухай тойм судалгаа явуулснаас хойш ийм төрлийн судалгаа орон даяар хийгдээгүй байна. Өнөөдөр Монголд хэвлэлийн эрх чөлөө ямархуу түвшинд хэрэгжиж байгааг эерэг, сөрөг байр сууринаас дүгнэж, ярьж бичих хүн цөөнгүй байгаа боловч бодит байдалд үнэлэлт өгөхөд тус дэм болохуйц судалгааны материал, баримт сэлт ховор байна. Нөгөө талаар нийгэм, улс төр, эдийн засгийн хөгжлийг дагаад олон түмний санал бодол, үнэт зүйлсийн утга агуулга байнга өөрчлөгдөж байдаг тул байгаа байдлыг баримтжуулан, өөрчлөлт, хөгжлийн чиг хандлагыг тодруулах зорилгоор энэхүү судалгааг явуулав.

“Монголын хэвлэл мэдээллийн байдлын талаарх олон нийтийн үнэлэмж” судалгаа нь Монголын хэвлэл мэдээллийн байдлыг тал бүрээс нь тандах зорилгоор Хэвлэлийн Хүрээлэнгээс явуулж буй багц судалгааны нэг хэсэг юм. Энэхүү судалгааны зэрэгцээ мэдээлэл авах орчин, сэтгүүлчдийн эрх, үүрэг хариуцлагын талаар өөр нэгэн судалгааг Pact World-ын Монгол дахь салбартай хамтран явуулж буйг дурдахад таатай байна.

СУДАЛГААНЫ ЗОРИЛГО

“Монголын хэвлэл мэдээллийн байдлын талаарх олон нийтийн үнэлэмж” санал асуулга нь иргэд хэвлэл мэдээллийн байдлыг хэрхэн үнэлж, хэвлэлийн эрх чөлөөний талаар ямархуу ойлголттой байгааг тандахыг зорьсон юм. Мөн нийслэл хотод болон хөдөө орон нутагт мэдээлэл авах орчин эрс ялгаатай байгааг харгалзаж, энэхүү ялгаа нь хэвлэлийн эрх чөлөөний тухай ойлголт, үнэлэмж, мэдээллийн хэрэгслийг ашиглаж буй байдалд хэрхэн нөлөөлж буйг тодруулахыг зорив.

Ингэснээр сэтгүүлчид, эрдэмтэн судлаачид, иргэний нийгмийн төлөөлөгчид Монголын хэвлэл мэдээллийн байдалд ул суурьтай дүгнэлт хийж, хэвлэл мэдээллийн эрх чөлөөг хөгжүүлэн бэхжүүлэхэд идэвхтэй оролцоход нь тус дөхөм болохыг хичээсэн юм.

СУДАЛГААНЫ АРГАЧЛАЛ

“Монголын хэвлэл мэдээллийн байдлын талаарх олон нийтийн үнэлэмж” санал асуулгыг анкетын аргад түшиглэн сурвалжлагын хэлбэрээр явуулсан болно.

Судалгааг орон даяр явуулахдаа хот, хөдөөгийн нийт 758 хүнийг түүвэрлэн хамруулсан. Ингэхдээ, Монгол Улсын 21 аймгийг

-хүн амын тоо

-хэвлэл мэдээллийн хөгжлийн түвшин /тогтвортой үйл ажиллагаа явуулж буй хэвлэл мэдээллийн хэрэгслийн тоо, сонин хэвлэлийн борлуулалт, радио телевизийн нэвтрүүлгийн цаг /

-газар зүйн болон хүн амын амьдралын хэв шинж, онцлог /хэл, уламжлалт ёс заншил /зэргийг харгалзан ижил төстэй байдлаар нь зургаан бүлэгт хувааж, бүлэг тус бүрээс тухайн бүлгийг төлөөлүүлэн нэг аймгийг сонгож судалгаанд хамруулсан юм. Ийнхүү Баян-Өлгий, Булган, Дархан-Уул, Дорноговь, Өвөрхангай, Хөвсгөл аймаг түүвэрт орсны зэрэгцээ нийслэлийн найман дүүргийг /Багануур, Баянгол, Баянзүрх, Сонгино-Хайрхан, Сүхбаатар,

Налайх, Хан-Уул, Чингэлтэй/ хамрууллаа. Сонгогдсон аймаг тус бүрээс бусад сумдыг төлөөлж чадахуйц нэг нэг сумыг сонгож, аймгийн төвд болон сумдад судалгааг явуулсан юм. Судалгааг явуулах үеэр зарим нэг бэрхшээл гарч байсныг тэмдэглэх нь зүйтэй болов уу. Тухайлбал, Баян-Өлгийн аймгийн хүн амын амьдралын хэв шинж, онцлогийг харгалзан тус аймгийг судалгааны түүвэрт багтаасан юм. Баян-Өлгийн аймагт, ялангуяа аймгийн төвөөс зайдуу сумдад монгол хэлээр үл ойлголцох бэрхшээл тулгарч, судалгааны анкетыг газар дээр нь казак хэлнээ орчуулах шаардлага гарч байв. Мөн судалгааны мэдээлэл цуглуулах үе сонгуулийн сурталчилгааны үетэй давхцаж, судалгааны зорилгыг андуу ташаа ойлгох, аль нэг улс төрийн намаас явуулж байгаа хэмээн үзэж асуултад хариулахаас цааргалах зэрэг тохиолдол ялангуяа орон нутагт гарч байв. Гэвч эдгээр бэрхшээл нь судалгааны эцсийн үр дүнд ямар нэг байдлаар нөлөөлөөгүй гэдгийг тэмдэглэе.

Судалгааны түүврийг сонгохдоо, судалгаанд оролцогчдын хүн ам зүйн бүтэц онцлогийг Монгол улсын хүн ам зүйн бүтцэд дүйцүүлэх үүднээс квотын арга ашигласан. Ялангуяа хөдөө орон нутгийн амьдралын хэв маягаас шалтгаалж санамсаргүй түүврийн аргаар судалгаанд оролцогчдыг сонгоход бэрхшээлтэй байдаг учир квотын арга нь энэхүү судалгаанд илүү тохиромжтой байх болно хэмээн үзсэн юм.

СУДАЛГААНД ОРОЛЦОГСДЫН НИЙГЭМ ХҮН АМ ЗҮЙН ҮЗҮҮЛЭЛТ

Судалгаанд 758 хүн хамруулсныг нас, хүйс, ажил эрхлэлтийн байдлаар нь ангилвал:

	Насны бүлэг	Хувь
1	16 – 19	14.3
2	20 – 34	41.3
3	35 – 49	30.1
4	50-аас дээш насныхан	14.3

Хүйс	Хувь
Эр	50,2
Эм	49,8

Судалгаанд оролцогсдын боловсрол, ажил эрхлэлтийн байдал

№	Боловсролын төвшин	Хувь
1	Бага	7.6
2	Бүрэн бус дунд	15.3
3	Бүрэн дунд	29.3
4	Тусгай дунд	13.0
5	Дээд	31.7
6	Эрдмийн зэрэгтэй	2.0
7	Бусад	0.3
8	Боловсролгүй	0.2

	Ажил эрхлэлтийн байдал	Хувь
1	Дунд сургуулийн сурагч	6.0
2	Оюутан	11.6
3	Төрийн бус байгууллагад	7.2
4	Төрийн байгууллагад	19.8
5	Хувиараа хөдөлмөр эрхэлдэг	16.0
6	Хувийн байгууллагад	12.2
7	Тэтгэвэрт	4.0
8	Малчин	8.8
9	Ажилгүй	13.2
10	Бусад	1.2

Судалгаанд оролцогсдын өрхийн орлого

№	Өрхийн орлогын хүрэлцээний хэлбэр байдал	Хувь
1	Өдөр тутмын ойр зуурын хэрэгцээнд ч хүрэлцдэггүй (хоол, унд гэх мэт)	12.5
2	Өдөр тутмын хэрэгцээндээ л дөнгөж хүрдэг	35.1
3	Өдөр тутмын хэрэгцээгээ хангахын зэрэгцээ зарим үед хувцас хунар авдаг	44.2
4	Эдгээрээс гадна үнэ цэнэтэй зүйл авчихдаг	5.4
5	Хэрэгцээнээсээ илүүчилж хуримтлал бий болгож чаддаг	2.8

**Судалгаанд оролцогсдын дэмждэг
улс төрийн нам, эвсэл**

№	Улс төрийн нам хүчин	Хувь	№	Улс төрийн нам хүчин	Хувь
1	БНН	1.7	5	Аль ч нам урсгалыг дэмждэггүй	29.7
2	МАХН	32.5	6	Бусад	2.2
3	Эх орон-Ардчилал эвсэл	26.9	7	Мэдэхгүй	6.1

СУДАЛГААНЫ ДҮНГЭЭС

ХОТ, ХӨДӨӨД ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ХЭРЭГСЛИЙГ ХЭРХЭН АШИГЛАЖ БАЙНА ВЭ!


Хэвлэлийн Хүрээлэнгээс 2003 оны эцэст явуулсан Монголын хэвлэл мэдээллийн мониторингийн судалгааны дүнгээс үзэхэд, Монгол Улсад тогтмол хэвлэгдэн гарч байгаа сонины тавны нэг нь /170 сониноос 32 нь/ орон нутгийн чанартай мэдээлэл түгээх үүрэг зорилго бүхий аймаг, сумын сонин байв. Орон нутгийн сонины борлуулалт нийт сонины борлуулалтад дөнгөж 2 хувийг эзэлдэг. Телевизийн хувьд, зөвхөн Улаанбаатар хотод 5 телевиз 7 хоногт нийт 382 цагийн /нэг телевиз өдөрт дунджаар 9 цагийн/ нэвтрүүлэг цацаж байсан бол, орон нутагт нэг аймагт нэгээс хоёр телевиз ажиллаж, өдөрт дунджаар 1,8 цагийн нэвтрүүлгийг зөвхөн аймгийн төвд болон зэргэлдээх ганц нэг суманд цацдаг.

Радиоогийн хувьд, сүүлийн жилүүдэд орон нутагт FM радио шинээр бий болж, орон нутгийн радиоогийн тоо нэмэгдэж байгаа боловч хөдөөг Улаанбаатар хоттой харьцуулшгүй аж. Улаанбаатар хотод Монголын радиогоос гадна 14 FM радио тус бүр өдөрт дунджаар 14 цагийн нэвтрүүлэг цацаж байна. Тэгвэл орон нутагт 9 аймагт орон нутгийн радио байхгүй, бусад аймагт нэгээс хоёр радио өдөрт дунджаар 4 – 8 цагийн нэвтрүүлэг явуулдаг аж.

Мэдээллийн эх үүсвэрийн төрөл, тоо нэмэгдэх тусам тэдгээрийн ашиглалт сайжирч байна уу? Хот, хөдөөгийн хэвлэл мэдээллийн ялгаатай байдал нь тухайн газар

амьдарч буй иргэдийн сонин унших, радио сонсох, телевиз үзэх байдалд хэрхэн нөлөөлж байна вэ?


“Монголын хэвлэл мэдээллийн байдлын талаарх олон нийтийн үнэлэмж” санал асуулгын дүнгээс үзэхэд, Улаанбаатар хотод сонин хэвлэл, радио телевизээр мэдээлэл авах боломж илт давуу байгаа хэдий ч хотынхон мэдээллийн хэрэгслийг орон нутгийнхнаас илүү их ашигладаг буюу хотынхны амьдралд сонин хэвлэл илүү чухал үүрэг гүйцэтгэдэг хэмээн дүгнэж боломгүй байв. Улаанбаатар хотод ч, орон нутагт ч, дотоодын мэдээлэл авах хамгийн чухал хэрэгсэлд нэгдүгээрт телевиз, хоёрдугаарт сонин, гуравдугаарт найз нөхөд, гэр бүлийнхэн, дөрөвдүгээрт радио орж байна. Эдгээр мэдээллийн эх сурвалжийг ач холбогдлоор нь эзлүүлсэн дэс дараалал нь хот, хөдөөд ижил байгаа төдийгүй, бусад эх сурвалжтай харьцуулах хувийн жин нь ч хот хөдөөд нэг их ялгарахгүй байгаа юм. Тухайлбал судалгаанд оролцсон Улаанбаатарын иргэдийн 34% нь дотоодын мэдээллийг юүн түрүүнд телевизээс авдаг гэсэн бол хөдөөд ч мөн адил судалгаанд оролцогчдын 34% нь ийн хариулжээ. Сонин хэвлэл, найз нөхөд ч мэдээлэл түгээгчийн хувьд хот хөдөөд төстэй үүрэг гүйцэтгэж байгаа бөгөөд харин радиог мэдээлэл авах зорилгоор хөдөөд арай илүү ашигладаг байна.



Гэвч яг ямар мэдээллийн хэрэгслийг хот, хөдөөд түлхүү ашиглаж байна вэ гэвэл зарим ялгаа ажиглагдаж байв.

Тухайлбал, Монголын Үндэсний Радиогоос дотоодын мэдээллийг голчлон авдаг хүмүүсийн тоо хөдөөд хотынхоос хоёр дахин илүү, Монголын Үндэсний Телевизийг чухалчилдаг иргэд хөдөөд хотоос 1,5 дахин илүү байна. Өөрөөр хэлбэл орон нутагт амьдарч буй хүмүүс үндэсний хэмжээний мэдээллийн хэрэгслийг түлхүү ашиглаж, тухайн аймгийн радио телевизийг төдийлөн чухалчлахгүй байгаа нь харагдаж байв.

Нөгөө талаар, мэдээллийн хэрэгслээр дамжуулан авч буй мэдээлэл нь иргэдийн сонирхолд нийцсэн, тэдний хүссэн мэдээлэл байж чадаж байгаа эсэхийг тандахад, хот хөдөөгийн хооронд нэлээд ялгаа ажиглагдсан. Тухайлбал, “Та хүссэн мэдээллээ хэвлэл мэдээллийн хэрэгслээс авч чаддаг уу” гэсэн асуултад хотоос судалгаанд орологчдын 45 хувь нь чаддаг гэсэн бол ингэж хариулсан хөдөөгийн иргэд хотынхоос 22 хувиар бага байна. Хөдөөгийн иргэд өөрийн амьдарч буй нутгийн мэдээллийн хэрэгслийг төдийлөн ашигладаггүй, үндэсний хэмжээний радио, телевизэд илүү ач холбогдол өгдөг боловч тэдгээр нь тэдний мэдээллийн хэрэгцээг бүрэн дүүрэн хангаж чаддаггүй гэсэн дүр зураг тодорч байна. Орон нутгийн мэдээллийн хэрэгсэл хүртээмж муутай /цөөн удаа цөөхөн цаг, хязгаарлагдмал газар нутагт нэвтрүүлдэг/ байдаг, гэтэл үндэсний хэмжээний радио телевиз орон нутгийн ахуй амьдралын сэдвийг тэр бүр хөнддөггүй тул ийнхүү хөдөөгийн иргэд мэдээллийн хэрэгслийг хотынхонтой ижил хэмжээнд ашигладаг боловч мэдээллийн хэрэгцээгээ тэр болгон хангаж чаддаггүй байж болох юм. /2002 онд Хэвлэлийн Хүрээлэнгээс явуулсан “Телевизийн мэдээллийн хөтөлбөрийг задлан шинжлэх судалгаа”-наас үзэхэд, МҮТВ-ийн мэдээллийн хөтөлбөрөөр хөдөө орон нутгийн сэдвийг хөндсөн нь нийт сэдвийн 5 хувийг эзэлж байсан. Эдгээрийн дийлэнхдээ тухайн аймгийн засаг даргын үйл ажиллагаатай холбоотой байв/



МЭДЭЭЛЛИЙН ХЭРЭГСЛИЙН ИРГЭДИЙН АМЬДРАЛД ГҮЙЦЭТГЭХ ҮҮРЭГ ӨӨРЧЛӨГДӨЖ БАЙНА



Дээр дурдсанчлан, 2004 оны 5-р сарын байдлаар хот, хөдөөд мэдээлэл авдаг гол эх сурвалж нь нэгдүгээрт телевиз, хоёрдугаарт сонин хэвлэл, гуравдугаарт бусдын яриа, дөрөвдүгээрт радио орж байв. Тэгвэл энэ байдал өмнөх жилүүдээс хэр ялгаатай байгааг тандаж үзье.

1988 онд ШУА-ийн Философ Социологи Эрхийн Хүрээлэнгээс, 1997 онд Хэвлэлийн Хүрээлэнгээс, 1999 онд МРТХЭГ-ын Социологийн судалгааны албанаас, 2002 онд МҮР-ийн судалгаа, захидал, харилцааны албанаас тус тус орон даяар явуулсан судалгааны дүнг дээрх дүнтэй харьцуулж үзвэл, телевизийг мэдээллийн эх үүсвэр болгон ашиглах нь нэмэгдэж, радиогийн үүрэг буурсан байна.

Мэдээлэл авах хамгийн чухал эх сурвалж				
1988	1997	1999	2002	2004
1. Радио 2. Сонин 3. Телевиз	1. Сонин 2. Телевиз 3. Радио	1. Телевиз 2. Радио 3. Сонин	1. Телевиз 2. Сонин 3. Радио	1. Телевиз 2. Сонин 3. Бусдын яриа 4. Радио

ХОТ, ХӨДӨӨД СОНИН УНШИЖ БУЙ БАЙДАЛ

Хамгийн их уншиж буй сонины хувьд, хотод өдөр тутмын болон бидний “шар” хэмээн нэрлэж заншсан 7- 10 хоног тутмын сонины аль алиныг нь, тухайлбал “Өдрийн сонин”, “Өнөөдөр”, “Сэрүүлэг”, “Хүмүүсийн амьдрал” сонинг сонирхон уншиж байгаа нь ажиглагдсан бол хөдөөд “шар” сонин унших хандлага давамгайлж байв. “Өдрийн сонин”-г хотоос судалгаанд оролцогчдын 53,1 хувь нь тогтмол уншдаг гэсэн бол хөдөөний иргэдийн 30,9 хувь нь энэ сонинг уншдаг гэжээ.



Хот, хөдөөд сонин уншигчдыг боловсролоор нь ялгаж үзвэл, хотод хамгийн их уншиж буй /Өдрийн сонин, Өнөөдөр, Сэрүүлэг, Хүмүүсийн амьдрал/ сонинуудын уншигчдын дийлэнх хувь нь дээд боловсролтой хүмүүс байх агаад, өдөр тутмын сонин уншигчдын дунд дээд боловсролтой хүмүүсийн эзлэх хувь арай илүү байна. Хөдөөд хамгийн олон уншигчтай сонины тоонд “Сэрүүлэг”, “Хүмүүс”, “Зууны мэдээ” орж байгаа бөгөөд, эдгээр сонины уншигчдын дийлэнх хувь нь бүрэн дунд болон тусгай дунд боловсролтой байв.

Хотод бага болон бүрэн бус боловсролтой хүмүүс сонин унших нь харьцангуй бага байсан бол хөдөөд сонин унших байдал боловсролын бүх түвшинд харьцангуй жигд байна.

Хот		Боловсролгүй	Бага болон бүрэн бус дунд	Бүрэн дунд болон тусгай дунд	Дээд/ эрдмийн зэрэгтэй
	Өдрийн сонин		3%	42%	56%
	Өнөөдөр		5%	32%	63%
	Сэрүүлэг	1.5%	8.5%	40.0%	50.0%
	Хүмүүсийн амьдрал	1.0%	7%	40%	52%
Хөдөө	Сэрүүлэг	2%	31%	42%	25%
	Хүмүүс	1%	29%	43%	27%
	Зууны мэдээ	0	29%	35%	35%

ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ИТГЭЛ ҮНЭМШИЛ

1998 онд Философ, Социологи, Эрхийн Хүрээлэнгээс 1700 хүний дунд явуулсан “Чөлөөт хэвлэл мэдээлэл өнөөдөр” санал асуулгын дүнгээр, судалгаанд оролцогчдын 6 хувь нь хэвлэл мэдээлэлд бүрэн итгэдэг, 70,4 хувь нь заримдаа эргэлздэг, 16,4 хувь нь их эргэлздэг буюу ер нь итгэдэггүй гэж хариулсан байв.

Энэ байдлыг “Монголын хэвлэл мэдээллийн байдлын талаарх олон нийтийн үнэлэмж” санал асуулгын дүнтэй харьцуулж үзэхэд, хэвлэл мэдээллийн итгэл үнэмшил 6 жилийн өмнөхөөс харьцангуй дээрдсэн дүр зураг харагдаж байна. Манай судалгааны дүнгээр, судалгаанд оролцогчдын

19,5 хувь нь хэвлэл мэдээллийн хэрэгслээр цацаж буй мэдээлэлд бүрэн итгэдэг, 64 хувь нь зарим үед эргэлздэг, 6,5 хувь нь огт итгэдэггүй гэжээ.

Хэвлэл мэдээллийн итгэл үнэмшил		
	1998	2004
Бүрэн итгэдэг	6 %	19.5%
Зарим үед эргэлздэг	70.4 %	64%
Итгэдэггүй	16.4 %	6.5 %
Хэлж мэдэхгүй байна	7.2 %	10%

Хэвлэл мэдээллээр цацаж буй мэдээлэлд бүрэн итгэдэг хүмүүсийн дунд эмэгтэйчүүд илүү олон байгаа бол тийм ч сайн итгэдэггүй буюу зарим үед эргэлздэг хүмүүсийн тоонд эрчүүд илүү байна.

	Эр	Эм
Бүрэн итгэдэг	41 %	59%
Зарим үед эргэлздэг	55 %	45 %
Итгэдэггүй	53%	47%
Хэлж мэдэхгүй байна	43%	57%

Хэвлэл мэдээллийн итгэл үнэмшил, нэр хүндтэй шууд холбоотой өөр нэг асуултыг бид судалгаанд оролцогсод тавьж үзсэн юм. Иргэд үг хэлэх, хэвлэн нийтлэх эрхээ эдэлж, нийгмийн амьдралд оролцох боломжоо хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан хэрэгжүүлэх сэтгэл санааны бэлэн байдал хэр байна вэ? Мэдээллийн хэрэгсэл тэдэнд тулгарч буй асуудлыг шийдвэрлэхэд тус болно гэсэн ойлголт, итгэл үнэмшил хэр байна вэ гэдгийг тандах үүднээс бид судалгаанд оролцогсод

“Та аль нэг асуудлаар өөрийн санал, шүүмжлэлээ

илэрхийлж, төр засаг, эрх бүхий албан тушаалтан, олон нийтэд хандахыг хүсвэл юун түрүүн ямар арга хэрэгсэл сонгох вэ?” хэмээн асуусан юм.

Ийм тохиолдолд хот, хөдөөгийн иргэдийн аль аль нь тухайн асуудлыг хариуцах хүнтэй биечлэн уулзахыг юун түрүүнд чухалчилж байна. Гэхдээ хөдөөгийн иргэдийн хувьд “биечлэн уулзах” болон “захидал бичих” арга замын аль аль нь бараг ижил ач холбогдолтой байхад, хотынхны хувьд, “биечлэн уулзахаас” гадна “радио, телевизэд хандах” нь өөрийгөө илэрхийлэх хоёрдугаар арга болох аж.



ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ТУХАЙ ОЛОН НИЙТИЙН ОЙЛГОЛТ, ҮНЭЛЭМЖ

1998 онд ШУА-ийн ФСЭХүрээлэнгээс явуулсан хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай судалгаанд оролцогчид, хэвлэл мэдээлэл эрх чөлөөтэй байна гэдэг бол **нэгдүгээрт** хэвлэл мэдээлэл санхүүгийн хувьд бие даасан байх, **хоёрдугаарт** ямар ч сэдвээр чөлөөтэй ил тод бичдэг байх, **гуравдугаарт** төр засгийг шүүмжилдэг байхыг хэлнэ хэмээн үзсэн байв. Тэгвэл “Монголын хэвлэл мэдээллийн байдлын талаарх олон нийтийн үнэлэмж” санал асуулгын дүнгээс үзэхэд, иргэд хэвлэл мэдээллийн эрх чөлөөг юун түрүүнд хэвлэл мэдээллийн байгууллагын санхүүгийн эрх чөлөөтэй уялдуулж ойлгох нь багасч, энэ бол иргэдийн өөрсдийнх нь үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө мөн хэмээн ойлгох болсон байна.

№	Хэвлэл мэдээллийн эрх чөлөө Таны бодлоор	%
1	Иргэд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх	24,8%
2	Сэтгүүлчдийн чөлөөтэй бичиж нийтлэх эрх чөлөө	23.6%
3	Гадны дарамт нөлөөгүй байх	22.3%
4	Төр хэвлэл мэдээллийн хэрэгсэлд хяналт тавихгүй байх	13.1%
5	Хэвлэл мэдээллийн хэрэгсэл санхүүгийн хувьд бие даасан байх	10.6%
6	Мэдэхгүй	4.0%
7	Бусад	1.5 %

ӨНӨӨДӨР МОНГОЛ УЛСАД ХЭВЛЭЛИЙН ЭРХ ЧӨЛӨӨ ЯМАРХУУ ТҮВШИНД ХЭРЭГЖИЖ БАЙНА ВЭ!

1998 онд Хэвлэлийн Хүрээлэнгээс улс төрч, сэтгүүлчид, хэвлэл мэдээллийн хэрэглэгчид гэсэн гурван бүлгийн дунд Монголын хэвлэл мэдээллийн хэрэгслийн чөлөөт байдлын тухай судалгаа явуулснаас, хэрэглэгчдийн бүлэг тухайн үеийн хэвлэл мэдээллийн эрх чөлөөг хэрхэн үнэлснийг сонирхоё. Судалгаанд оролцогчдын 10 хувь нь хэвлэлийн эрх чөлөө бүрэн хангагдсан, 60 хувь нь эхлэл төдий, 15 хувь нь огт байхгүй, 14 хувь нь мэдэхгүй хэмээн хариулсан байв.

Дээрх судалгаанд зөвхөн Улаанбаатар хотын иргэд оролцсон тул, дурьдсан үнэлэмжийг “Монголын хэвлэл мэдээллийн байдлын талаарх олон нийтийн үнэлэмж” санал асуулгад Улаанбаатар хотоос оролцогсдын саналтай харьцуулъя:

Монголд хэвлэлийн эрх чөлөө ямар түвшинд хэрэгжиж байна вэ		
Улаанбаатар хотод	1998	2004
1. Бүрэн хэрэгжиж байна	10 %	42.6 %
2. Төдийлэн сайн хэрэгжихгүй байна / эхлэл төдий байна	60 %	46.5 %
3. Эрх чөлөө байхгүй	15 %	0.9 %
4. Мэдэхгүй	14 %	9.7%
5. Бусад	1 %	0.3 %

Дээрх хүснэгтээс үзэхэд, хэвлэлийн эрх чөлөө бүрэн хангагдсан хэмээн үзэж буй хүмүүсийн тоо сүүлийн 6 жилд эрс нэмэгдэж, “Төдийлөн хэрэгжихгүй байна”, “Хэвлэл мэдээллийн эрх чөлөө алга” хэмээн үзэж буй иргэдийн тоо нэлээд багассан боловч, судалгаанд оролцогчдын дийлэнх хувь нь “Хэвлэлийн эрх чөлөө ерөнхийдөө байгаа, гэвч төдийлөн сайн хэрэгжихгүй байна” гэж үзэж байна.

Энэ бол Улаанбаатар хотод амьдарч буй иргэдийн үнэлгээ. Судалгаанд хөдөө орон нутгаас оролцогчид хэвлэлийн эрх чөлөөг хэрхэн үнэлснийг сонирхоход, зарим ялгаа ажиглагдаж байв.

Тухайлбал, хэвлэлийн эрх чөлөө бүрэн хангагдсан хэмээн үзэж буй иргэд хөдөө орон нутагт арай олон, “төдийлөн сайн хэрэгжихгүй байна” гэж үздэг хүний тоо хотод илүү, мөн хэвлэлийн эрх чөлөө ямархуу байгааг дүгнэж мэдэхгүй хүний тоо хөдөөд бага зэрэг илүү байв.



Хэвлэл мэдээллийн эрх чөлөө байна, эсвэл байхгүй хэмээн үнэлэхэд иргэдийн сонин хэвлэл хэр уншдаг байдал, эсхүл тэдний улс төрийн үзэл бодол нөлөөлж байгаа эсэхийг тандах үүднээс бид дараах аргыг хэрэглэсэн юм. Юун түрүүнд, хэвлэлийг ямар хэлбэрээр олж уншиж байгаагаас шалтгаалан судалгаанд оролцогчдыг 3 хэсэгт хуваалаа. Хэвлэлийг захиалж, худалдан авч уншигчид нь

хэрэглэгчдийн идэвхтэй бүлэг, дамжуулж, олдсоноо уншдаг нь дундаж, бараг уншдаггүй юмуу огт уншдаггүй бол идэвхгүй бүлэгт орно. Ийнхүү бүлэглэхэд, судалгаанд оролцогсодын 45% нь идэвхтэй бүлэг, 49% нь дундаж, 6% нь идэвхгүй бүлэгт багтаж байв. Бүлэг тус бүрээс хэвлэлийн эрх чөлөө бий эсэхийг хэрхэн үнэлснийг нь харьцуулж үзвэл дараах дүр зураг гарч байна.

№		Идэвхтэй бүлэг	Дундаж бүлэг	Идэвхгүй бүлэг
1	Эрх чөлөөтэй	45%	44%	34%
2	Төдийлөн эрх чөлөөтэй биш	47%	43%	29%
4	Огт эрх чөлөөгүй	2%	2%	1%
5	Хэлж мэдэхгүй	6%	10%	36%

Энэхүү харьцуулалтаас хэвлэл мэдээллийн идэвхтэй бүлгийн үнэлгээ “Төдийлөн эрх чөлөөтэй биш”, идэвхгүй бүлгийн хариулт “хэлж мэдэхгүй” дээр төвлөрсөн байгааг харж болно.

Судалгаанд оролцогсдын улс төрийн үзэл бодол, чиг баримжаа хэвлэлийн эрх чөлөөний үнэлгээнд хэрхэн нөлөөлж буйг тодруулъя.

№		Эх орон Ардчилал эвслийг дэмждэг	БНН-ыг дэмждэг	МАХН-ыг дэмждэг	Бусад	Алийг нь ч дэмждэггүй	Мэдэхгүй
1	Эрх чөлөөтэй	23%	2%	47%	2%	22%	4%
2	Төдийлөн эрх чөлөөтэй биш	35%	2%	20%	2%	35%	6%
3	Огт эрх чөлөөгүй	64%	0	27%	0	9%	11%
4	Хэлж мэдэхгүй	2%	17%	28%	0	42%	88%

Улс төрийн үзэл баримтлалаар эрх чөлөөг үнэлэх байдалд зарим ялгаа байгааг харж болно. Тухайлбал Хэвлэл мэдээллийн эрх чөлөө бүрэн хангагдсан гэж үзэж буй хүмүүсийн дийлэнх нь буюу 47 хувь нь МАХН –ыг дэмжигчид байхад, “огт эрх чөлөөгүй” гэж үзэж буй хүмүүсийн дийлэнх нь “Эх орон-Ардчилал” эвслийг дэмжигчид байна. Нэгэн зүйлийг тэмдэглэхэд, хэвлэл

мэдээллийн эрх чөлөө Монголд алга хэмээн үзэж буй хүмүүсийн дунд МАХН-ыг дэмжигчид ч нэлээдгүй байгаа аж. Хэвлэлийн эрх чөлөөний байдлын талаар дүгнэлт өгч чадаагүй хүмүүсийн дийлэнх нь мөн тодорхой нам, эвслийг дэмждэггүй хүмүүс байв.

Хэвлэлийн эрх чөлөө хэрхэн хэрэгжиж буйн нэгэн хэмжүүр бол, сэтгүүлчид, хэвлэл мэдээллийн хэрэгсэл тэнцвэртэй мэдээллийг түгээж буй эсэх юм. Энэ талаар олон нийт, хэвлэл мэдээллийн хэрэглэгчид ямар бодолтой байгааг тодруулъя.

Улаанбаатарт судалгаанд оролцогдсоос дунджаар 44 хувь нь хэвлэл мэдээллийн хэрэгсэл ерөнхийдөө олон ургальч мэдээллийг дамжуулдаг хэмээн үзэж байгаа бөгөөд, мэдээллийн хэрэгсэл тус бүрийн олон ургальч чанарыг үнэлүүлэхэд, 25-р телевиз хамгийн олон ургальчаар шалгарч, Монголын Үндэсний Телевиз олон ургальч чанараар хамгийн таарууд орсон байв.



Хотынхны үнэлгээг орон нутагт амьдарч буй иргэдийнхтэй харьцуулахад, Улаанбаатарт хамгийн өрөөсгөл мэдээлэлтэйгээр “шалгарсан” Монголын Үндэсний Телевиз болон Монголын Үндэсний Радио орон нутагт хамгийн тэнцвэртэй, олон ургальч мэдээллийн хэрэгслээр шалгарсан байв. Хөдөөгийн иргэд өөрийн орон

нутгийн сонин хэвлэлийг хамгийн тэнцвэргүй, мэдээлэл дамжуулахдаа аль нэг талыг дагнан барьдаг хэмээн үнэлжээ.



ХЭВЛЭЛИЙН ЭРХ ЧӨЛӨӨНД ЮУ САЙНААР НӨЛӨӨЛЖ БАЙНА ВЭ!

“Хэвлэл мэдээллийн эрх чөлөө хөгжихөд юу сайнаар нөлөөлж байна вэ?” гэсэн асуултад “сайнаар нөлөөлж буй зүйл алга” хэмээн хариулсан хүний тоо хамгийн бага байгааг доорх хүснэгтээс харж болно. Судалгаанд оролцогсдын ихэнх нь хэвлэл мэдээллийн хэрэгсэл олширч, хүн бүхэн хүссэн сэдвээрээ бичих боломжтой байгаа нь хэвлэлийн эрх чөлөө хөгжихөд эерэгээр нөлөөлж байна хэмээн үзэж байв. Эерэгээр нөлөөлж буй хүчин зүйлсийн дунд хамгийн бага үүрэгтэй нь “Одоогийн засгийн газрын бодлого” аж.

№	Хэвлэлийн эрх чөлөөнд юу сайнаар нөлөөлж байна вэ	Хариулсан давтамж
1	Хэвлэл мэдээллийн хэрэгсэл олширч байгаа нь	29.9%
2	Бүх сэдвээр бичих нээлттэй байгаа нь	24.9%
3	Хүн бүхэн хэвлэн нийтлэх боломжтой нь	12.0%
4	Олон нийт идэвхтэй болсон	12.0%
5	ХМ-ийн байгууллага санхүүгийн хувьд боломжтой болсон нь	9.5%
6	Одоогийн засгийн газрын бодлого	5.3%
7	Мэдэхгүй	5.1%
8	Сайнаар нөлөөлж байгаа зүйл алга	2.2%

ХЭВЛЭЛИЙН ЭРХ ЧӨЛӨӨНД ЮУ СААД БОЛЖ БАЙНА ВЭ ?

Хэвлэлийн эрх чөлөө хөгжихөд сөргөөр нөлөөлж буй хүчин зүйлсийг судалгаанд оролцогсод

1-рт хэвлэл мэдээллээр худал хуурмаг зүйл мэдээлж буй байдал


2-рт сэтгүүлчдийн хариуцлага сул байгаа байдал

3-рт хэвлэл мэдээллийн хэрэгслүүд төрийн харъяалалд байж, улс төрийн нам, хүчний дуу хоолой болж байгаа явдал хэмээн нэрлэжээ.

Хэвлэлийн эрх чөлөө бэхжихэд юу саад болж байна вэ?		
	Хариултын утга	Хариулсан давтамж
1	Хэвлэл мэдээллээр худал хуурмаг зүйл мэдээлэх нь	28%
2	Төрийн харъяалалд байж нам хүчний дуу хоолой болох	17%
3	Сэтгүүлчид хариуцлагагүй байх	17%
4	Шар сонины эрээ цээргүй байдал	14%
5	Одоогийн засгийн газрын бодлого	7%
6	Зарим хэвлэл мэдээллийн хэрэгсэлийн ноёрхол	5.20%
7	ХМ-ийн байгууллага санхүүгийн хувьд хараат байх	4.20%
8	Мэдээлэл авах боломж хаалттай байх	4%
9	Редакци сэтгүүлчдийн харилцаа муудах	2.50%
10	Мэдэхгүй	0.20%

СҮҮЛИЙН ЖИЛУУДЭД ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ЭРХ ЧӨЛӨӨТ БАЙДАЛ ХЭРХЭН ӨӨРЧЛӨГДСӨН БЭ!

“Хэвлэлийн эрх чөлөө сүүлийн үед хумигдаж байна” хэмээн үзэх сэтгүүлчид, хэвлэл мэдээллийн ажилтнууд нэлээдгүй байдаг. Харин хэрэглэгчид тэгж үзэхгүй байгаа нь судалгаанаас харагдав. Сүүлийн 4 – 5 жилийн хугацаанд хэвлэлийн эрх чөлөө хэрхэн өөрчлөгдсөн тухай асуулт тавихад, судалгаанд оролцогчдын дийлэнх нь буюу 61 хувь нь “дээрдсэн” хэмээн хариулжээ. “Мэдэхгүй” хэмээн хариулсан хүмүүсийн тоо нэлээдгүй байсан бөгөөд, харин “дордсон” гэж үзсэн хүмүүсийн тоо хамгийн бага байв.



Хэвлэлийн эрх чөлөөний байдал хэрхэн өөрчлөгдсөн тухай үнэлгээнд иргэдийн улс төрийн үзэл баримтлал хэрхэн нөлөөлж буйг тандвал дараах дүр зураг гарч байна.

Сүүлийн 4-5 жилд хэвлэл мэдээллийн эрх чөлөө хэрхэн өөрчлөгдсөн бэ?							
№		Эх орон Ардчилал Эвслийг дэмждэг	БНН-ыг дэмждэг	МАХН-ыг дэмждэг	Бусад	Алийг нь ч дэмждэггүй	Мэдэхгүй
1	Дээрдсэн	22%	1%	38%	2%	32%	5%
2	Хэвэндээ	37%	4%	27%	3%	25%	4%
3	Дордсон	56%	2%	20%	2%	10%	10%
4	Мэдэхгүй	21%	0	27%	3%	36%	13%

Дээрх хүснэгтээс үзэхэд, Хэвлэлийн эрх чөлөө сүүлийн 4-5 жилд дээрдсэн гэж үзэж буй хүмүүсийн дийлэнх нь МАХН-ыг дэмждэг, дордсон гэж үзэж буй хүмүүсийн дийлэнх нь Эх орон Ардчилсан Эвслийг дэмждэг хүмүүс байна. Хэвлэлийн эрх чөлөөг хэрхэн өөрчлөгдөж буйг мэдэхгүй хэмээн хариулсан хүмүүсийн дийлэнх нь улс төрийн тодорхой үзэл баримтлалгүй, аль нэг намыг дэмждэггүй хүмүүс байв.